

**“УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2024 оны 04-р сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

“Улсын их дэлгүүр” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04-р сарын 26-ны өдрийн 09:00 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Чингисийн өргөн чөлөө гудамж, “Номин юнайтед” төвийн 4.5 дугаар давхарт биечилсэн хэлбэрээр зохион байгуулав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд цахимаар оролцсон хувьцаа эзэмшигч байгаагүй.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 24/06 дугаар тогтоолоор томилогдсон хурлын дарга Я.Наваан, тооллогын комиссын дарга, эдийн засагч Г.Өсөхбаяр, тооллогын комиссын гишүүн хуульч Г.Мягмартуяа, нягтлан бодогч Н.Сүрэнжав, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Өлзийбат нарын бүрэлдэхүүнтэйгээр хурлын үйл ажиллагааг зохион байгуулав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зард тусгасны дагуу хуралд биечлэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн иргэний цахим үнэмлэх, бичиг баримтыг шалгасны үндсэн дээр Тооллогын комисс хурлын ирцийг бүртгэх ажлыг 08:20 цагаас 09:15 цаг хүртэл хугацаанд хийв.

Хурлын үйл ажиллагааг 09:15 цагт эхлүүлэв.

Хурлын дарга Я.Наваан: “Улсын их дэлгүүр” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 сарын 26-ны өдөр биечилсэн болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулах тухай шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 03 сарын 11-ний өдрийн хурлаас гаргасан. Гэхдээ энэ удаагийн хуралд цахим хэлбэрээр оролцож буй хувьцаа эзэмшигч байхгүй байна. Мөн энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах эрхийг ТУЗ-ийн дарга Я.Наваан надад олгосон. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссыг Г.Өсөхбаяр, Г.Мягмартуяа, Н.Сүрэнжав гэсэн 3 хүний бүрэлдэхүүнтэй томилсон байна. Ингээд “Улсын их дэлгүүр” ХК-ийн 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал эхэлж байгааг мэдэгдье.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлуудыг ТУЗ-өөс баталсныг та бүхэнд танилцуулъя.

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах.
2. ТУЗ-ийн 2024 оны зардлын төсвийг батлах.
3. ТУЗ-ийн гишүүдийг сонгох.

Тооллогын комисс хурлын ирцийг танилцуулна уу.

Тооллогын комиссын дарга Г.Өсөхбаяр: Энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 19,583,925 ширхэг хувьцааны саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид буюу компанийн нийт хувьцааны 53.2%-ийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид оролцож байгаа учраас Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт заасны дагуу хурлын ирцийг хүчинтэйд тооцож байна.

Нийт 32 хувьцаа эзэмшигч урьдчилан саналын хуудсаар саналаа өгснийг хурлын ирцэд оруулан тооцсон болно.

Хурлын дарга Я.Наваан: За хуралд нийт хувьцаа эзэмшигчдийн 53.2% нь оролцож байгаа учир хурлын ирц хүчин төгөлдөр болж байна. Хурлын ирц бүрдсэн учраас хурлын үйл ажиллагааг эхлүүлье. Хурлаар хэлэлцэх нэгдүгээр асуудал буюу компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах асуудалд оръё. Компанийн үйл

ажиллагааны тайланг ТУЗ-ийн дарга миний бие танилцуулъя. Хувьцаа эзэмшигчдэд энэхүү мэдээлэл материалыг брокерын компаниудаар дамжуулан урьдчилан хүргүүлсэн байгаа.

ХУРЛААР ХЭЛЭЛЦСЭН НЭГДҮГЭЭР АСУУДАЛ:

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны талаар:

2023 оны эхний хагас жилд “Улсын Их Дэлгүүр” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр Я.Наваан, С.Сайнбат, И.Галбуян, А.Норсмаа, Х.Эрдэнэбаатар, Т.Сарантуяа нар Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээр П.Эрдэнэболд, Д.Дашцэдэн, Н.Батцацрал нар, ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар М.Өлзийбат, компанийн Гүйцэтгэх захирлаар И.Галбуян нар ажиллалаа.

ТУЗ-ийн ердийн гишүүн С.Сайнбат, ТУЗ-ийн хараат бус гишүүн Н.Батцацрал, Д.Дашцэдэн нар ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасантай холбогдуулан ТУЗ-ийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор Монгол Улсын Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.5 дахь хэсэгт заасныг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 08-р сарын 09-ний өдрийн 23/09 тоот тогтоолоор дараагийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийг шинээр сонгох хүртэл ажлаас чөлөөлөгдсөн ТУЗ-ийн гишүүдийн оронд ТУЗ-ийн хараат бус гишүүний шаардлагыг хангасан М.Дамирансүрэн, М.Ганцэцэг, Н.Энхчимэг нарыг түр томилсон.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 09-р сарын 11-ний өдрийн 23/12 тоот тогтоолоор И.Галбуянг компанийн Гүйцэтгэх захирлын үүрэгт ажлаас өөрийнх нь хүсэлтээр чөлөөлж, Гүйцэтгэх захирлаар Х.Эрдэнэбаатарыг томилсон.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн хэтийн төлөв, зорилтыг тодорхойлон хууль, дүрэм, журамд заасан эрх үүргийнхээ хүрээнд компанийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, түүний дэргэдэх хороод нь хорооны эрх мэдлийн хүрээнд ТУЗ-ийн болон Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавьж, өдөр тутмын удирдлагаар ханган ажиллаж ирлээ.

Төлөөлөн удирдах зөвлөл тайлант хугацаанд нийт 7 удаа хуралдаж, гүйцэтгэх удирдлагын шийдвэрлүүлэхээр санал оруулсан асуудлуудыг цаг тухайд нь бүрэн шийдвэрлэж ажилласан.

Компанийн 2023 оны үйл ажиллагааны талаар:

2023 онд “Улсын Их Дэлгүүр” ХК нь түрээсийн орлогыг нэмэгдүүлэх, дэлгүүрийн барилгын сэргээн босголт, шинэчлэлтийн ажлыг бүрэн дуусгах, өдөр тутмын ашиглалтын зардлыг хэмнэн ажиллахад анхааран ажиллаж ирсэн.

2009 – 2010 оны хооронд нийт 7 тэрбум төгрөгийн барилгын их засвар үйлчилгээ хийж, орчин үеийн өнгө төрхөд нийцүүлж, үйлчлүүлэгчийн ая тухай үйлчлүүлэх нөхцлийг бүрдүүлсэн.

2020 оны 6 сард учирсан галын хохирлыг арилгах, барилгын сэргээн босголт, сайжруулалттай холбоотойгоор 2021 – 2022 оны хооронд нийт 16 тэрбум төгрөгийн барилгын ажил хийж гүйцэтгэсэн.

(гээд доорх зургуудыг дэлгэц дээр үзүүлэв)






Улсын их дэлгүүрийн барилгын 1-6 давхрын таазны парapedны хашлаганд нерж гоёл хийх ажил, 2-7 дугаар давхрын агааржуулалтын хэсэгчилсэн засварын ажлууд тус тус хийгдсэн. (гээд доорх зургийг үзүүлэв)



Улсын их дэлгүүрийн барилгын 1-5 давхрын дээврийн засварын ажил, 1-р давхрын гадна саравчны засварын ажил хийгдсэн. (гээд доорх зургийг үзүүлэв)



Компанийн 2023 оны санхүүгийн тайлангийн талаар:

“Улсын Их Дэлгүүр” ХК нь “Номин Реалтор” ХХК-тай байгуулсан Түрээсийн гэрээний дагуу түрээсийн орлогыг 2023 онд 10%-иар нэмэгдүүлж, 8,310.6 сая төгрөгийн цэвэр орлоготой, 8,204.0 сая төгрөгийн зардалтай, 106.6 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.



Улсын төсөвт нийт 457.7 сая төгрөгийн татвар, хураамж төлсөн. Үүнд:

НӨАТ: 226.3 сая.төг
 ҮХХАТ: 184.2 сая.төг
 ХХОАТ: 10.6 сая.төг
 НДШ: 22.8 сая.төг
 ГТ: 13.8 сая.төг

Нягтлан бодох бүртгэл ба тайлагналын талаар:

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас сонгогдсон хөндлөнгийн Аудитын байгууллага болох "Сүлд-Аудит" ХХК-ийн зүгээс "Улсын их дэлгүүр" ХК-ийн санхүүгийн тайлан тэнцэл нь Монгол Улсын Сангийн Яамнаас баталсан "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны жагсаалт", "Дансны үлгэрчилсэн заавар"-ын дагуу аккрузль сууриар бэлтгэгдсэн ба энэхүү тайлагналын суурь нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын стандарттай нийцэж байна гэж дүгнэсэн.

"Сүлд Аудит" ХХК-иас дараах асуудал дээр зөвлөмж өгсөн. Үүнд:

1. Шүүхийн шийдвэрийн дагуу үүссэн авлага, өглөгийг санхүүгийн тайланд тусгаж ажиллах.

Компанийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцэлд тусгагдсан санхүүгийн үзүүлэлтүүд:

Санхүүгийн байдлын тайланд:

Компанийн нийт хөрөнгийн үнийн дүн 15,195,748,918.40 төгрөг, богино хугацаат өр төлбөрийн дүн 592,225,815.76 төгрөг, урт хугацаат өр төлбөрийн дүн 17,000,000,000 төгрөг, өр төлбөрийн нийт дүн 17,592,202,852.42 төгрөг байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар компанийн хуримтлагдсан ашиг алдагдалтай буюу -7,634,733,691.18 төгрөг байна.

Орлогын дэлгэрэнгүй тайланд:

Нийт ашиг /алдагдал/ 8,310,638,334.26 төгрөг, татварын дараах цэвэр ашиг 106,577,286.43 төгрөг, орлогын нийт дүн 106,577,286.43 төгрөг байна.

(гээд компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг дараах байдлаар танилцуулав)

**КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ДҮГНЭЛТ**

1. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

- a. ОРЛОГО: "Улсын их дэлгүүр" ХК нь 2023 онд үндсэн үйл ажиллагаанаас 7,510,638,000 төгрөгийн түрээсийн орлоготой ажилласан.
- b. ЗАРДАЛ: "Улсын их дэлгүүр" ХК нь 2024 онд үндсэн үйл ажиллагаандаа 7,172,160,000 төгрөгийн төсөв зарцуулсан.
- c. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ, АЛДАГДАЛ: "Улсын их дэлгүүр" ХК нь дээрх орлого болон зардалд үндэслэн 2023 онд үндсэн үйл ажиллагаанаасаа 338,478,000 төгрөгийн ашиг олсон байна.

2. ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГАА:

- a. БУСАД ОРЛОГО: "Улсын их дэлгүүр" ХК нь 2023 онд Нийслэлийн Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 01-р сарын 13-ны өдрийн 001/ХТ2023/00147 дугаартай шийдвэр, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2023 оны 04-р сарын 21-ний өдрийн 210/МА2023/00845 дугаартай магадлал, Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн 2023 оны 07-р сарын 04-ний өдрийн шүүх хуралдааны 001/ХТ2023/00147 дугаартай тогтоолын дагуу хариуцагч нараас 800,000,000 төгрөгийн төлбөр хүлээн авсан.

- b. **БУСАД ЗАРДАЛ:** "Улсын их дэлгүүр" ХК нь 2023 онд Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 11-р сарын 15-ны өдрийн 2022/ШЦТ/889 дугаартай шийдвэр, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2023 оны 04-р сарын 06-ны өдрийн 2023/ДШМ/381 дугаартай магадлал, Монгол Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын нийт шүүгчдийн 2023 оны 07-р сарын 06-ны өдрийн хуралдааны 517 дугаартай тогтоолын дагуу бусдад 1,031,901,000 төгрөгийн төлбөр төлсөн.
- c. **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС АШИГ, АЛДАГДАЛ:** "Улсын их дэлгүүр" ХК нь дээрх бусад орлого болон бусад зардалд үндэслэн 2023 онд үндсэн бус үйл ажиллагаанаасаа 231,901,000 төгрөгийн алдагдал хүлээсэн байна.
3. **ЦЭВЭР АШИГ:** "Улсын их дэлгүүр" ХК нь 2023 онд үндсэн үйл ажиллагаанаас 338,478,000 төгрөгийн ашиг олж, үндсэн бус үйл ажиллагаанаасаа 231,901,000 төгрөгийн алдагдал хүлээснээр нийт 106,577,000 төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.
4. **ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ:** 2023 онд 47,572,000 төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөсөн байсан ба бодит гүйцэтгэлээр 106,577,000 төгрөгийн цэвэр ашигтай ажилласнаар төлөвлөгөөний биелэлт 224% буюу 124%-иар давуулан биелүүлсэн байна.
5. **ДҮГНЭЛТ:** Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн биелэлтийг хангалттай гэж дүгнэв.

За ингээд хурлаар хэлэлцэх 1-р асуудалтай холбоотой танилцуулгыг хийж дууслаа. Компанийн тухай хуульд заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулъя.

Компани тайлант жилийн болон өмнөх онуудад бий болсон хуримтлагдсан алдагдлаа нөхөж чадаагүй, мөн Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 2022/ШЦТ/889 дугаартай шийдвэр, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 2023/ДШМ/381 дугаартай магадлал, Монгол Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын нийт шүүгчдийн хуралдааны 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 517 дугаартай тогтоолын дагуу Улсын их дэлгүүрийн барилгад гарсан гал түймэртэй холбогдуулан бусдад 6,139,722,534 төгрөгийн хохирол төлөх үүрэгтэй болсон зэрэг шалтгааны улмаас Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт заасан ногдол ашиг хуваарилах шаардлагыг хангаж чадахгүй байх тул 2023 оны тайлант жилийн үйл ажиллагааны орлогоос хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн байна.

ХУРЛААР ХЭЛЭЛЦСЭН ХОЁРДУГААР АСУУДАЛ:

Дараагийн хэлэлцэх асуудал бол Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны зардлын төсвийг батлах асуудал байгаа. (гээд зардлын төсвийг дараах байдлаар танилцуулав)

1. Цалингийн зардал

д/д	ТУЗ-ийн гишүүдийн цалин		Нэг удаагийн хуралд /төгрөг/	2024 онд төлөвлөсөн хурлын тоо	Нийт төлбөр /төгрөг/
	Төрөл	Тоо			
1	Ердийн гишүүний цалин	6	300,000	6	10,800,000
2	Хараат бус гишүүний цалин	3	500,000	6	9,000,000
Нийт зардал					19,800,000

2. Бусад зардал

д/д	Зардлын нэр төрөл	Нийт үнэ /төгрөг/
1	Хурал зохион байгуулах зардал (ТУЗ-ийн болон Хувьцаа эзэмшигчдийн хурал хамаарна)	2,400,000
2	Хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй бүртгэл авах зардал, бичиг хэрэг, нотариатын зардал (ТУЗ-ийн болон Хувьцаа эзэмшигчдийн хурал хамаарна)	2,300,000
3	Унааны зардал	350,000
Нийт зардал		5,050,000
НИЙТ ЗАРДЛЫН ТӨСӨВ		24,850,000

ХУРЛААР ХЭЛЭЛЦСЭН ГУРАВДУГААР АСУУДАЛ:

Энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх сүүлийн асуудал бол ТУЗ-ийн гишүүдийг шинээр сонгох асуудал байгаа. Хуульд заасны дагуу компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нийт 9 гишүүнтэй байх ба үүний 6 нь ердийн гишүүн, 4 нь хараат бус гишүүн байх ёстой. ТУЗ-ийн гишүүнд нийт 10 хүн нэр дэвшиж байгаа.

Ингээд та бүхэнд ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулъя.

ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчид:

1. Янсанжавын Наваан

Нийслэлийн 1-р дунд сургууль, МУИС-ийн, Эдийн засгийн сургуулийг Бизнесийн удирдлага мэргэжлээр төгссөн. ИБУИНВУ-ийн University of Wales сургууль бизнесийн удирлагын чиглэлээр магистрийн зэрэг хамгаасан. Худалдаа, үйлчилгээний чиглэлээр 17 жил гаруй ажилласан туршлагатай. "Улсын их дэлгүүр" ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр ажиллаж байна.

2. Идэштотгохын Галбуян

Ховд аймгийн Мөст сумын дунд сургууль, МУИС-ийн МКСургуулийг Хэрэглээний математикч мэргэжлээр төгссөн. "Номин даатгал" ХХК-д актуарч, албаны даргаар 6 жил 8 "Номин даатгал" ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар 3 жил, "Номин холдинг" ХХК-ийн Санхүүгийн бизнес хариуцсан захирлаар 1 жил, 2021 оны 3 дугаар сараас 2023 оны 09-р сар хүртэл "Улсын их дэлгүүр" ХК-ийн Гүйцэтгэх захирлаар, 2021 оноос "Улсын их дэлгүүр" ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр ажиллаж байна.

3. Алтангэрэлийн Норсмаа

Төв аймгийн 1-р 10-н жилийн сургууль, МУИС-ийн Эдийн засгийн факультетыг Нягтлан бодогч, эдийн засагч мэргэжлээр төгссөн. "АПУ" ХК-д ня-бо, ахлах ня-бо, ерөнхий нягтлан бодогч, "Фаст-Мани" Хадгаламж зээлийн хоршоог үүсгэн байгуулж ерөнхий нягтлан бодогчоор, "Номин Холдинг" ХХК-ийн Дотоод аудитын газарт ахлах дотоод аудитор, газрын дарга, Дотоод хяналт, эрсдэлийн үнэлгээний газрын захирлаар, "Эрдэнэт Хивс" ХХК-ийн Хяналтын зөвлөлийн дарга, "Хөвсгөл Усан зам" ХК-ийн Хяналтын зөвлөлийн гишүүн, "Номин Юнион" ХЗХ-ны Хяналтын

зөвлөлийн дарга, "Номин Холдинг" ХХК-ийн СНББГ-ын захирал, "Номин юнион" ХЗХ-ны Гүйцэтгэх захирал, 2021 оноос "Улсын их дэлгүүр" ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр ажиллаж байна.

4. Хүрэлхүүгийн Эрдэнэбаатар

Архангай аймгийн Хүмүүн II дунд сургууль, Санхүү эдийн засгийн дээд сургуулийг Бизнесийн эдийн засагч мэргэжлээр Бакалавр зэрэгтэй төгссөн. МУИС-ийн Эдийн засгийн сургуулийг Эдийн засагч мэргэжлээр магистр зэрэгтэй төгссөн. Монхангай группт Эдийн засагч, агуулахын менежер, Хас банкинд Зээлийн эдийн засагч, Бодь групп, "Улаанбаатар такси транспорт сервис" ХХК-д Санхүүгийн менежер, "Номин холдинг" ХХК-д Хэлтсийн захирал, 2021 оноос "Улсын их дэлгүүр" ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн, 2023 оны 09-р сараас "Улсын их дэлгүүр" ХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

5. Тэрбишийн Сарантуяа

Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургууль төгссөн. "Номин тав трейд" ХХК-д салбарын эрхлэгчээр 10 жил, "Номин тав трейд" ХХК-д Ахлах менежерээр 2 жил, 2021 оны 01 сараас одоог хүртэл "Номин тав трейд" ХХК-ийн дэлгүүрийн сүлжээ хариуцсан захирлаар, 2021 оноос "Улсын их дэлгүүр" ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр ажиллаж байна.

6. Төрөөгийн Амартөр

Ховд хотын 6-р дунд сургууль, МУИС-ийг Эдийн засагч мэргэжлээр төгссөн. Голомт банканд Эдийн засагчаар 6 сар, Монголбанканд Эдийн засагчаар 1 жил, "Номин холдинг" ХХК-д Стратеги төлөвлөлт, эх үүсвэрийн удирдлагын хэлтсийн даргаар 10 жил ажиллаж байгаа.

ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчид:

1. Мөнхнасангийн Дамирансүрэн

1964 онд Багшийн сургуулийн багш мэргэжлээр, 1979 онд УИС-ийг Хуульч мэргэжлээр төгссөн. 1979-1985 онд Батлан хамгаалах яаманд Хуулийн зөвлөхөөр, 1985-2021 онд Монгол Улсын Дээд шүүхэд шүүгч, зөвлөхөөр ажилласан. 2023 оны 08-р сараас "Улсын их дэлгүүр" ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр түр сонгогдон ажилласан.

2. Нанзаддоржийн Энхчимэг

2000 онд "Түшээ" дээд сургуулийг Эрх зүйч мэргэжлээр, 2001 онд МУИС-ийг Түүхч мэргэжлээр төгссөн. Монголын хуульчдын холбооны гишүүн хуульч, 2003 оноос хойш Өмгөөлөгчөөр ажиллаж байгаа. 2015 оноос хойш "Гранд партнерс" ХХН-ийн захирал, 2023 оны 08-р сараас "Улсын их дэлгүүр" ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр түр сонгогдон ажилласан.

3. Мэндсоогийн Ганцэцэг

2000 онд "Түшээ" дээд сургуулийг Эрх зүйч мэргэжлээр төгсөж, 2005 онд "Цагдаагийн академи"-д хууль зүйн магистрын зэрэг хамгаалсан. Монголын хуульчдын холбооны гишүүн хуульч, 2000-2004 онд "Сувд" хууль зүйн товчоонд хуульч, 2004-2005 онд Авто тээврийн газарт бүртгэлийн ажилтан, 2005-2006 онд "Хасагт хайрхан" ХЗС-д багш, 2006-2008 онд Иргэний нисэхийн ерөнхий газарт Мэдээллийн ажилтан, 2008-2012 онд Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яамны Далайн захиргаанд Хуулийн зөвлөх, 2012-2013 онд Зам тээврийн яаманд Мэргэжилтэн, 2008 оноос өмгөөлөгчөөр, 2023 оны 08-р сараас "Улсын их дэлгүүр" ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр түр сонгогдон ажилласан.

4. Батсуурийн Ганбаяр

1989-1999 онд Нийслэлийн 20-р дунд сургууль, 1999-2003 онд Сэрүүлэг дээд сургуулийг Бизнесийн удирдлага мэргэжлээр төгссөн. Бодлого судлалын төв ТББ-д мэргэжилтнээр 20 жил ажилласан. "АПУ" ХК-д СБНА менежерээр 4 жил ажилласан. "Апармент консалтинг" ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар 5 жил ажилласан.

Хурлын дарга Я.Наваан: За ингээд энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой танилцуулгыг хийж дууслаа. Ингээд хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчид санал хүсэлтээ хэлэх, асуулт асуух үе шат эхэлж байна. Санал хүсэлт хэлэх, асуулт асуух хувьцаа эзэмшигчид ээлж дарааллаараа гараа өргөөд, нэрээ тэмдэглүүлээд явъя.

Хувьцаа эзэмшигч Жаргалсайхан: Улсын их дэлгүүр ХК хувьчлагдсанаас хойш хувьцаа эзэмшигчид ерөөсөө ногдол ашиг авсангүй. Тэгээд сая судлаад үзсэн чинь 2020 оны тэр гал түймрийн асуудлаас хувьцаа эзэмшигчид бараг өрөнд орчихсон юм байна ш дээ. Тэр гал түймрийн нөхцөл байдлыг бас асууж тодруулмаар байна. Шүүх хурал энэ тэр болсон юм шиг байна. Гал түймрийн шалтгаан нь юу байсан бэ гэдгийг нарийн сайн мэдэхгүй байна. Тэрийг тодруулмаар байна. Тэгээд засварын ажил явагдсан юм бол тухайн засварын ажлыг манай Төлөөлөн удирдох зөвлөлийн шийдвэрээр засварын ажлыг хийлгэсэн юм уу эсвэл Номин холдинг ХХК засвар хийлгэсэн юм уу гэдэг асуудал гарч ирж байна. Хэрэв манай Төлөөлөн удирдах зөвлөл засварын ажил хийлгэх шийдвэр зөвшөөрөл өгсөн бол тэр галын хохирол өр төлбөр нь хувьцаа эзэмшигч бидэнтэй холбоотой холбоотой болж таарах гээд байна. Тийм бол бидний сонгосон ТУЗ-ийн гишүүд ийм шийдвэр гаргажээ гэж ойлгохоор байна. Аан хэрэв Номин компани компанийн шийдвэрээр Улсын их дэлгүүрийн барилгад засвар үйлчилгээ хийсэн бол гарсан хохирол өр төлбөрийг тэр Номин компани хариуцах ёстой гэж бодож байна. Тэгээд шүүхийн шийдвэр нь яаж гарсан шүүхээр асуудал яаж шийдэгдсэнийг сайн мэдэхгүй учраас ийм тодруулга байна. За 2-р асуудал нь Төлөөлөн удирдах зөвлөлийн нэр дэвшигчдийг сая танилцуулгыг нь харлаа. Үндсэндээ дандаа Номин компанийн хүмүүс харагдаж байна. Тэр дотор хувьцаа эзэмшигчдийн төлөөллийн хүн ерөөсөө алга. Нэг байгууллагаас яагаад ингээд бүгдийг нь сонгочихвоо гэдэг асуудал байна. Өөрөөр хэлбэл түрээслүүлэгч биднүүс түрээсэлж байгаа компанийн хүмүүсийг ТУЗ-д оруулчихжээ. Энэ одоо зөв үү буруу юу? 3-р асуудал нь бол ТУЗ-д ямар шалгуураар хүмүүсийг нэр дэвшүүлсэн бэ? Сая танилцуулсан хараат бус гишүүдийг сонгох шалгуур нь юу юм бэ? Заавал тусгай мэдлэг боловсролтой хүн байх ёстой юу? Эсвэл хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг хамгаалсан, тэд нартайгаа байнга холбогддог, харилцдаг хүмүүс байх ёстой юм уу? Миний бодлоор бол хувьцаа эзэмшигчидтэйгаа харилцдаг, тэдний эрх ашгийг хамгаалдаг тийм хүн ТУЗ-д байх ёстой болов уу гэж бодож байна. Дараагийн асуудал бол энэ нэр дэвшиж байгаа хүмүүс нь компанид хувьцаа эзэмшдэг хүмүүс үү? Мөн Гүйцэтгэх захирлын цалинг хэн тогтоодог вэ? Номин компани тогтоодог юм уу? Эсвэл ТУЗ тогтоодог юм уу? Эсвэл хувьцаа эзэмшигч нар тогтоох ёстой юм уу? Тэгээд маш их харамсалтай байна. Хувьцаа эзэмшигч байлаа гээд нэг ч төгрөгийн ногдол ашиг авсангүй. Бусад компаниуд ядаж нэг хүнд 20, 30 мянга төгрөг тарааж байна ш дээ. Жишээлбэл Сүү компани. Тэр чинь зүгээр л сүү үйлдвэрлэдэг л компани. Гэтэл манай компани байхгүй.

Хурлын дарга Я.Наваан: За би асуултанд нь хариулт өгье. Эхний асуулт нь ТУЗ-д нэр дэвшиж байгаа хүмүүст тавигдах шаардлагын талаар асуусан. Компанийн тухай хуулиар бол нээлттэй хувьцаат компани нь ТУЗ-ийн 9 гишүүнтэй байх ёстой. Үүний 6 хүн нь бол ердийн гишүүд буюу хувьцаа эзэмшигчдээс санал болгосон, тэдний төлөөллийн хүн байж болдог. Харин хараат бус 3 гишүүн нь бол хувьцаа эзэмшигчидтай харилцан хамааралгүй, нэгдмэл сонирхолгүй хүн байх ёстой. За эдгээр гишүүдийн мэдлэг, боловсрол, ур чадварын хувьд ердийн гишүүдэд бол харьцангуй босго шалгуур бага тавьдаг. Хувьцаа эзэмшигчийг төлөөлж ажиллаж чадаж байвал хэн ч байж болно гэсэн зарчмын юм байдаг. Харин хараат бус гишүүний хувьд дээр дурдсан хараат бус байдлын шинж чанарыг хадгалсан байх ёстой. Хараат бус гишүүнд бол тусгай мэргэжил боловсролын шаардлага тавигддаггүй. Гол шалгуур нь бол тухайн компанийн хувьцааны 20-оос дээш хувийн

хувьцааг эзэмшдэггүй, компанийн эрх бүхий албан тушаалтан биш, мөн тэдэнтэй ах дүү, төрөл садны харилцаа холбоогүй байх, бизнесийн хамтын ажиллагаа байхгүй байх гэсэн ийм тусгай шаардлага тавигддаг. За тэгээд түрүүн та Номин талын хүмүүс их байгаа юм бишүү гэж хэлсэн. Номин холдинг ХХК-ийн хувьцаа эзэмшигч Баярсайхан гэж хүн байдаг. Тэр хүн бол та бүгдийн л адил Улсын их дэлгүүр ХК-ийн хувьцаа эзэмшигч. Компанийн тухай хуулийн 66-р зүйлд зааснаар бол энгийн хувьцааны 5 болон түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч нь өөрийн төлөөллийн хүнээ ТУЗ-д нэр дэвшүүлээд санал болгоод явж болдог. Энэ хүрээнд Баярсайхан гэж хувьцаа эзэмшигч нь өөрийн төлөөллийн хүмүүсийг ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшүүлж санал болгож байгаа юм. Та бүхэн ч гэсэн компанийн энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшдэг бол мөн адил ТУЗ-ийн ердийн гишүүнд өөрийн төлөөллийн хүнээ нэр дэвшүүлээд явах боломжтой. 5 хувийн хувьцаа нь бол дунджаар 1 сая 800 мянга ширхэг хувьцаа эзэмшдэг хүний эзэмшлийн хувь байдаг. Харин ТУЗ-ийн хараат бус гишүүнд бол түрүүн хэлсэнчлэн хараат бус гишүүний шаардлагыг хангасан хэн ч гэсэн энэ Ганбаяр нэр дэвшигч шиг өөрийгөө болон өөрийн төлөөний хүнээ нэр чөлөөтэй нэр дэвшүүлээд явах боломжтой. Энэ удаагийн хуралд бол жижиг хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл болж Батсуурийн Ганбаяр өөрийн нэрийг хараат бус гишүүнд нэр дэвшүүлсэн. Хуралд өөрийн биеэр оролцож байна. ТУЗ-ийн хараат бус гишүүнд Ганбаяраас өөр нэрээ дэвшүүлсэн хүн байхгүй байна. За Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс авсан тархалтын судалгаан дахь мэдээллээр бол ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж байгаа эдгээр хүмүүс дотор компанид хувьцаа эзэмшдэг хүн байхгүй. Дараагийн асуулт бол ногдол ашгийн талаар асуудал байсан. Ногдол ашгийн хувьд бол компани өмнө нь 2002, 2008, 2012 онд 3 удаа ногдол ашиг хуваарилж байсан. Компани 36 сая ширхэг хувьцаандаа боломжтой байдлаар ногдол ашиг тарааж байсан түүх бол бий. Компанийн удирдлагын зүгээс бол Улсын их дэлгүүрийн барилгын өгнө зүсийг улам сайжруулж, тодорхой хэмжээний хөрөнгө оруулж засвар үйлчилгээ хийх юм бол хувьцааны үнэ цэнэ нь улам өсөх юм байна гэсэн бодлого чиглэл барьж ажиллаж ирсэн. Үүний дагуу өмнө нь хэд хэдэн үе шаттай томоохон хэмжээний хөрөнгө оруулалтыг хийж дэлгүүрийн барилгыг сайжруулан засаж байсан. Тухайлбал анхны томоохон засвар буюу дэлгүүрийн дотор зайг хөндий атриум болгож, урсдаг шат хийх зэрэг ажлыг 2005, 2006 оны үед хийж байсан. Ингэснээр түрээслэх боломжтой худалдааны зай талбай нэмэгдсэн. Түүний дараагаар бид гал түймрийн хохирол амссан боловч бид нэгэнт зассаных улам илүү сайжруулж өнгө зүсийг нь өөд татах ийм ажлуудыг хийсэн. Ингэснээр Улсын их дэлгүүр нь бусад томоохон дэлгүүрүүдтэй харьцуулахад хамаагүй илүү амжилттай ажиллаж байгаа гэж бодож байна. Тухайлбал Энхтайваны өргөн чөлөөнд байрладаг 2, 3 их дэлгүүр бол бараг захын түвшинд очоод муудаж байгааг бид бүхэн мэдэж байгаа. Мэдээж компани бол ногдол ашиг тараахын төлөө чармайн ажиллаж байгаа. Үүний зэрэгцээ компани хувьцааныхаа үнэ цэнийг өсгөх, компанийнхаа тогтвортой олон жилийн үйл ажиллагааны амжилтыг хадгалах бодлогыг барьж ажиллаж ирсэн. Гал түймрийн талаар мөн асуусан. 2020 оны 6-р сард Улсын их дэлгүүрийн барилгад томоохон хэмжээний гал гарч хохирол учирсан. Тухайн үед улсын түүх соёлын дурсгал, онцгой объект гэдэг утгаар маш олон төрийн байгууллага, хууль хүчний байгууллагууд газар дээр нь ажилласан. Мөн Номин холдинг ХХК-ийн компанийн зүгээс өөрийн 2000 гаруй ажилтныг дайчилж бүтэн сарын турш өдөр шөнөгүй ажиллуулсан бөгөөд гал түмрийн хохирлын хэмжээг тогтоох, түрээслэгч нарын бараа бүтээгдэхүүнийг тоолж хүлээлгэн өгөх, нэмж хохирол учрахаас урьдчилан сэргийлэх зэрэг ажлуудыг хийсэн. Холбогдох төрийн байгууллагуудын зүгээс та нар галын хохирлыг тогтоох, таслан зогсоох асуудалд маш сайн зохион байгуулалттай ажилласан гэдэг сайшаал талархал бас ирж байсан. Аз болж бид дэлгүүрт байсан түрээслэгч нарын бараа бүтээгдэхүүнийг бараг 90 гаруй хувьтай даатгуулсан байсан учраас харьцангуй хохирол багатайгаар тухайн нөхцөл байдлыг даван туулж чадсан. Ингэснээр түрээслэгч нарын хохирлыг даатгалын компаниуд нөхөн төлсөн учраас түрээслэгч нарын зүгээс компаниас нэхэмжлэх хохирлын хэмжээ харьцангуй бага болох нөхцөл бүрдсэн. Үүний дараагаар бид дэлгүүрийн барилгаа яаралтай засан сайжруулахгүй бол болохгүй байсан. Тухайн үеийн гүйцэтгэх захирал шуурхай арга хэмжээнүүдийг авч ажилласан. Төлөөлөн удирдах зөвлөлтэйгөө зөвлөлдсөний үндсэн дээр барилгын засварын ажлын зургийн компаниудыг олох, гүйцэтгэгч компаниудыг сонгон шалгаруулж олох зэрэг асуудлууд тулгарсан. Гэтэл тухайн гүйцэтгэгч компаниудад төлөх ёстой ажлын хөлс, материалын зардлыг хаанаас гаргаж өгөх вэ гэдэг асуудал мөн тулгарсан. Засварын ажилд олон тэрбум төгрөгийн санхүүжилт

шаардлагатай болсон. Ингээд бид ерөнхий түрээслэгч болох Номин реалтор ХХК-д санал тавьсан. Та нар барилгын үйл ажиллагаа эрхэлдэг юм чинь Улсын их дэлгүүрийн барилгын засварын ажлыг хийгээд өгөөчээ. Ингэхдээ биднээс мөнгө төгрөг урьдчилж авахгүйгээр өөрөөсөө санхүүжилтийг гаргаад хийгээд өг гэдэг санал тавьсан. Уг асуудлаа Төлөөлөн удирдах зөвлөлдөө танилцуулж холбогдох зөвшөөрлийг авсан. Уг саналыг Номин реалтор ХХК хүлээн авсан тул бид барилгын ажлын захиалагчийн чиг үүргийг тус компанид шилжүүлж засварын ажлыг хийж гүйцэтгүүлсэн. За ингээд барилгын засварын ажлын дараа Номин реалтор ХХК-д гарсан зардлыг төлөх шаардлага үүссэн бөгөөд компани үүнийг санхүүжүүлэх мөнгө төгрөгийн асуудлыг зохицуулах шаардлагатай болсон. Энэ санхүүжилтийн талаар өмнөх жилүүдийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлууд дээр хувьцаа эзэмшигч нарт мөн танилцуулж байсан. Барилгын засварын ажилд нийтдээ 15.4 тэрбум орчим төгрөгийн зардал гарсан. Тухайн хөрөнгө оруулалт, санхүүжилтийг маргаангүй байлгах үүднээс хөндлөнгийн аудитын байгууллага сонгож хяналт тавиулж ажиллаж байсан. Барилгын засварын ажлын гүйцэтгэгч нарын сонгон шалгаруулах ажлыг бол Номин реалтор ХХК өөрөө хариуцан хэрэгжүүлсэн.

За ингээд хурлын дэгийнхээ дагуу дараагийн хувьцаа эзэмшигчийн санал хүсэлт, асуултыг сонсьё.

Хувьцаа эзэмшигч Батаа: За түрүүн бол хурлын дарга ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавигдах шаардлагыг тайлбарласныг сонслоо. Тухайн хараат бус гишүүнд жижиг хувьцаа эзэмшигч нарын зүгээс нэр дэвшиж орох боломж байдаг юм уу? 2-р асуудал бол хувьцаа эзэмшигчдийн хурлын зараа нийтэд сайн хүргэж тавьж өгөөч гэж хэлмээр байна. Миний мэдэж байгаагаар бол Ийгл телевизээр хэдэн удаа зар явж байсан. Зараа сайн тавьж өгөхгүй бол хуралд хувьцаа эзэмшигчдийн оролцоо хангалтгүй байдал харагдаад байна. Мөн манай компанид facebook сошиал хаяг энэ тэр байдаг уу?

Хурлын дарга Я.Наваан: За таны асуултад хариулъя. ТУЗ-ийн хараат бус гишүүнд хувьцаа эзэмшигчид өөрийн төлөөний хүнийг чөлөөтэй санал болгож нэр дэвшүүлж болно. Бид хуулийн хугацаанд буюу 40-өөс доошгүй хоногийн өмнө хурлаа зарлаж байгаа. Энэ хугацаанд хувьцаа эзэмшигч нар хэлэлцэх асуудалтай танилцаж байгаад нэр дэвшүүлэх хүнээ чөлөөтэй санал болгох боломжтой. Тухайлбал энэ удаагийн хуралд нэрээ дэвшүүлсэн Ганбаяр шиг ингээд өөрийгөө чөлөөтэй нэр дэвшүүлээд явах боломжтой юм. Хурлын зарын хувьд бид цаашид анхаарч ажиллая. Хурлын зарыг бид боломжоороо хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүргэхийг зорьж ажиллаж байгаа. За дараагийн хувьцаа эзэмшигчийн санал, асуултыг сонсьё.

Хувьцаа эзэмшигч Ганболд: За миний хувьд өмч хувьчлалын үеэр цэнхэр ягаан тасалбараар хувьцаа эзэмшигч болж байсан. 308 ширхэг хувьцаатай хүн. Өмнө нь ерөөсөө энэ компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг сонирхдоггүй явж байгаад саяхан facebook дээрээс хурлын талаарх мэдээллийг олж үзээд өнөөдрийн хуралд оролцохоор шийдсэн. ТУЗ-ийн нарийн бичгийн даргаас хурлын танилцуулга материалыг авч танилцсан. Санхүүгийн тайлан дээрээс 3 асуулт асууя. 1-р асуулт бол санхүүгийн тайлангаас харахад ТУЗ 2023 онд 47.5 сая төгрөгийн ашигтай ажиллана гэж төлөвлөсөн байна. Энэ надад их сонин санагдаад байна. Ийм том компани 47.5 хан сая төгрөгийн ашигтай ажиллана гэж төлөвлөчихөөд санхүүгийн тайлан дээрээ 126 сая төгрөгийн ашигтай ажилласан гээд төлөвлөгөөний биелэлт 224 хувьтай гэж дурдсан байна. Бараг төлөвлөгөөгөө 124 хувиар давуулан биелүүлсэн юм шиг ийм үзүүлэлт харагдаад байна. Тэгэхээр ТУЗ яагаад 2023 оны төлөвлөгөөндөө 47.5 сая төгрөгийн ашигтай ажиллана гэж төлөвлөсөн юм бэ? Мөн энэ удаагийн хурлын хэлэлцэх асуудалд яагаад компанийн 2024 оны төлөвлөгөө байхгүй байгаа вэ? 2-р асуулт бол санхүүгийн тайланд дээр компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс бага болсон байна гэж бичигдсэн байна. Яагаад компанийн хөрөнгийн хэмжээ хувь нийлүүлсэн хөрөнгөөс бага байна вэ? За мөн санхүүгийн тайлан дээр компанийн 2023 оны мөнгөн орлого 2022 оныхоос багассан харагдаж байна. 18 тэрбумаас 10 тэрбум болж бараг 80 хувиар буурсан байна. Энэ ямар учиртай вэ? Мөн компанийн авлага, өглөгийг харлаа. Авлагын 98 хувь

буюу 698 сая төгрөг нь НӨАТ-ын авлага гээд байна. Энэ юун НӨАТ-ын авлага вэ? Энийг сайн ойлгохгүй байна. Өглөгийн хувьд 97.3 хувь нь зээл болоод зээлийн хүү гэж байна. Сая компани 7 тэрбум төгрөгийн зээл авсан гэж ойлголоо. Дээрх өглөгт гал түймрийн улмаас учирсан хохиролд төлсөн 1 тэрбум гаран төгрөг орж байгаа юм уу? Түүнээс гадна ерөнхий болоод удирдлагын зардал 5.4 тэрбум төгрөг гэж байна. Үүнээс зөвхөн удирдлагын зардал нь хэдэн төгрөг юм бэ гэдгийг салгаад хэлээд өгөөч. Дараагийн асуулт бол Компанийн тухай хуульд зааснаар компанийн үндсэн зорилго бол ашгийн төлөө байх ёстой. Тэгэхээр манай хувьцаат компани бол ашгийн төлөө этгээд байх ёстой. Би бага зэрэг судлаад үзэхэд Санхүүгийн зохицуулах хороо манай Улсын их дэлгүүр ХК-ийг шүүхэд өгсөн юм байна. Анхан шатны шүүх дээр бол компани ялаад харин давж заалдах шатны шүүх болон Улсын дээд шүүх дээр Санхүүгийн зохицуулах хороо ялаад үүний дагуу тодорхой хариуцагч этгээдүүдээс компани 4.4 тэрбум төгрөгийн авлагатай гэж гарсан юм байна. Энэ шүүхийн шийдвэрийн биелэлт ямар шатандаа явж байгаа вэ? Тэр 4.4 тэрбум төгрөгийг манай компани хариуцагч этгээдүүдээс авах юм уу үгүй юм уу? Энэ шүүхийн шийдвэрүүдээс харахад Улсын их дэлгүүр компани бүх талбайгаа Номин реалтор компанид хямд үнээр түрээслүүлээд нөгөөх нь цаашаа дахиад хэд хэд дамжуулан өндөр үнээр түрээслүүлдэг ийм байдал харагдаж байна. Үүнээс болоод компани ашиггүй ажиллаж байна. Энэний улмаас ногдол ашгаа өгч чадахгүй болж байна. Түүхэндээ ногдол ашиг өгч байгаагүй.

Хурлын дарга Я.Наваан: За би хариулт өгье. Компанийн тухай хуульд зааснаар ТУЗ компанийн бизнес төлөвлөгөөг баталдаг. Үүний дагуу ТУЗ жил болгон компанийн бизнес төлөвлөгөөг хянаж танилцаад гүйцэтгэх захиралд тодорхой үүрэг чиглэл өгөөд ингээд явдаг. 2023 онд яагаад 47.5 сая төгрөгийн ашигтай ажиллана гэж төлөвлөсөн бэ гэхээр түрүүн хэлсэнчлэн компани тодорхой үе шаттайгаар томоохон хөрөнгө оруулалтуудыг хийгээд явсан. 2005, 2006 онд эхний том хөрөнгө оруулалтууд хийгдсэн. Мөн жил бүр засвар үйлчилгээ, засан сайжруулалтын ажлууд хийгдээд явдаг. Сүүлийн жилүүдэд буюу 2020 оноос хойш 15.4 тэрбум төгрөгийн засвар үйлчилгээ хийх шаардлага үүссэн. Тэгэхээр энэ томоохон хөрөнгө оруулалтууд юугаар хийгддэг вэ гэхээр нэг талаас банк санхүүгийн байгууллагаас зээл авах байдлаар, нөгөө талаас түрээсийн орлогоо нэмэгдүүлэх байдлаар бүрдүүлээд явж байгаа. 2021 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаар компанийн стратеги төлөвлөгөөг баталж өгсөн байдаг. Энэ төлөвлөгөөгөөр Улсын их дэлгүүр нь улсын нүүр царай болсон түүхэн объект учраас компанийн үйл ажиллагааг урт хугацаанд нь үр ашигтай, тогтвортой байлгах ийм сонголтыг хийсэн гэж ойлгож байна. Энэний хүрээнд дэлгүүрийн талбайгаа бүхэлд нь түрээслүүлье гэдэг шийдвэр гарсан. Энэ шийдвэр нь 2021 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар сонирхлын зөрчилгүй жижиг хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр гарсан. Түүнчлэн худалдаа үйлчилгээний байгууллагуудын ашиг орлого, үйл ажиллагаа нь улсын инфляцийн түвшин, түүгээр ч барахгүй нүүрсний үнээс шалтгаалаад унадаг, босдог савлагаатай байдаг. Ийм эрсдэлт нөхцөл байдлаас урьдчилан сэргийлээд бүх талбайгаа бөөнд нь түрээслүүлэх сонголт нь зөв юм байна гэж үзээд хувьцаа эзэмшигч нар уг асуудлыг дэмжиж шийдвэр гаргаж өгсөн байдаг. Үүний дагуу Номин реалтор ХХК-тай бөөний түрээсийн гэрээ хийгдээд явж байгаа. Тус гэрээний дагуу сар бүр түрээсийн орлогоо ямар ч хоцрогдолгүйгээр 100 хувь аваад явж байгаа. Компани ийнхүү гэрээ хийхдээ 2022 оноос эхлэн түрээсийн орлогыг жил бүр тодорхой хувийн өсөлттэй байхаар гэрээлсэн байгаа. Түрээсийн орлогыг 2021 онд 15 хувиар, 2022 онд өссөн дүнгээс 10 хувиар, 2023 онд өссөн дүнгээс дахиад 10 хувиар өсгөж явж байгаа. Гэтэл зах зээлд бусад худалдаа, үйлчилгээний компаниуд яаж байна вэ гэхээр түрээсийн талбайн дунджаар 30 хувь нь хоосон байж байдаг. Үлдсэн 70 хувь талбайнхаа төлбөрийг бүрэн авч чаддаггүй ийм байдалтай байгаа. Харин Улсын их дэлгүүр ХК бол түрээсийн төлбөрөө цаг хугацаанд бүрэн авч, орлого нь тогтвортойгоор өсөөд явж байна. Энэ өсөлтийн үр дүнд мэдээж бид ашгийг нэмэгдүүлэхээр зорьж ажиллаж байгаа. 2023 онд бид 106 сая төгрөгийн ашигтай ажилласан. 2024 онд бүр илүү өндөр ашгийг төлөвлөн ажиллаж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн баталж өгсөн төлөвлөгөөг та бүхэн үзэж танилцаж болно. За түүнээс гадна хувьцаа эзэмшигч маань шүүхийн маргааны талаар тодорхой асуултууд асуусан. 2023 онд бол таны хэлсэнчлэн шүүхийн маргаан явсан. Шүүхээс тодорхой нэр бүхий хүмүүсээс Улсын их дэлгүүр ХК-д 4.4 тэрбум төгрөгийн төлбөр төлөх ёстой гэдэг ийм шийдвэр гарсан. Үүний дагуу манай гүйцэтгэх захирал болон ТУЗ-ийн зүгээс Санхүүгийн

зохицуулах хороотой зөвшилцсөний үндсэн дээр шүүхийн шийдвэрийн дагуу авах ёстой төлбөрийн хуваарийг тохиролцож гэрээ байгуулсан байгаа. Одоогийн байдлаар 1.2 тэрбум төгрөгийг компани хүлээж аваад байгаа. Хуваарийн дагуу улирал тутамд шүүхийн шийдвэрээр тогтоосон төлбөрийг аваад явж байгаа. Санхүүгийн тайлангийн үзүүлэлттэй холбоотой хувьцаа эзэмшигчийн асуултуудад манай гүйцэтгэх захирал Эрдэнэбаатар хариулт өгнө.

Гүйцэтгэх захирал Х.Эрдэнэбаатар: Санхүүгийн тайлан дээр нийт 600 гаруй сая төгрөгийн НӨАТ-ын авлага бүртгэлтэй байгаа. Энэ ямар учиртай авлага вэ гэхээр бид түрүүн хэлсэнчлэн галын хохиролтой холбоотойгоор 15.4 тэрбум төгрөгийн зардал гаргаж дэлгүүрийн барилгаа засварлах, сайжруулах ажлууд хийгдсэн. Уг засварын ажилд гүйцэтгэгчээр орж ажилласан байгууллагуудаас бид НӨАТ орсон дүнгээр гэрээ хийж ажиллуулсан. Хуулиараа бид татварыг суутган тооцох ёстой байдаг. Гэхдээ одоогоор түр авлага үүсгэсэн байгаа ба НӨАТ-ын авлагаа бага багаар суутган тооцоод явна. Өөрөөр хэлбэл хувьцаа эзэмшигчийн асуусан НӨАТ-ын авлага нь бол галын дараах барилгын засвар, сэргээн засварлалт, сайжруулалттай холбоотой үүссэн авлага байгаа юм.

Хурлын дарга Я.Наваан: Санхүүгийн тайлан дээр бусдаас авах авлага болон банканд төлөх зээл 2-ын хооронд гүйгдэж бичилт хийгдсэн. Дээр хэлсэнчлэн 15.4 тэрбум төгрөгийн барилгын ажлын засварын зардлыг санхүүжүүлэх зорилгоор бид олон банкуудруу хандаж зээл авах санал гаргасан боловч зээл олгох банк олдохгүй байсан. Ингээд Хаан банк 10 тэрбум төгрөг л өгөх боломжтой гэсэн. Гэхдээ зээл өгөхдөө Номин холдинг ХХК-тай хамтын ажиллагааны хүрээнд олгосон зээлийн шугамын эрхээс танай компанид зээл олгож болно гэсэн. Мөн Номин холдинг ХХК болон түүний хувьцаа эзэмшигч нар танай компанийг заавал батлан дааж байж зээл олгоно гэсэн шаардлага тавьсан. Уг шаардлагын дагуу Номин холдинг ХХК манай компанийг батлан даагаад Хаан банкнаас зээл авахуулсан. За ингэж явж байгаад Голомт банкнаас 2023 онд нэмэлт 7 тэрбум төгрөгийн зээл авах боломж үүссэн. Голомт банк мөн адил Номин холдинг ХХК-ийн батлан даалттайгаар зээл олгоно гэсэн. Тэгээд бид Номин холдинг ХХК-д зээлд батлан дааж өгөөч гэдэг хүсэлтийг тавьж зөвшөөрсөн. Түүгээр барахгүй Баярсайхан гэж хувьцаа эзэмшигч маань Улсын их дэлгүүр ХК-д эзэмшдэг өөрийн өмчлөлийн хувьцааг банканд барьцаалуулж байж сүүлийн 7 тэрбум төгрөгийн зээлийг авахуулсан. Бид барилгын засварын ажлаа хурдлуулахын тулд энэ 7 тэрбум төгрөгийг Номин реалтор ХХК-иас түр аваад ашигласан байсан. Тэгээд Голомт банкнаас авсан зээлээр Номин реалтор ХХК-ийн өрийг дарсан. Үүнтэй холбоотой бичилт санхүүгийн тайланд бичигдсэн байгаа юм. Эдгээр бүх зээлүүд ТУЗ-өөр хянагдаж зөвшөөрөгдөөд авсан зээлүүд байгаа. Зээлийн хүүгийн хувьд бол Хаан банк болон Голомт банкнаас бид маш хөнгөлөлттэй хүүгийн нөхцөлөөр зээл авсан. Бизнесийн зээлийн хүү 19-20 хувьтай явж байхад бид 15 орчим хувийн хүүтэй зээл авч чадсан.

Гүйцэтгэх захирал Х.Эрдэнэбаатар: За түрүүн хувьцаа эзэмшигчийн асуусан ерөнхий ба удирдлагын зардлын талаар би тайлбар өгье. Улсын их дэлгүүр ХК маань Гүйцэтгэх захирал, Ахлах нягтлан бодогч, тооцооны нягтлан бодогч, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга гэсэн ийм 4 хүний бүрэлдэхүүнтэй ажилладаг. Эдгээр хүмүүсийн цалин хөлсний зардал дээр нэмээд түрүүн та бүхэнд танилцуулсан ТУЗ-ийн гишүүдийн цалин зардал нэмэгдээд жилийн нийт дүнгээр 145 сая төгрөгийн удирдлагын зардал гаргасан байна.

Хурлын дарга Я.Наваан: За хувьцаа эзэмшигчдийн санал хүсэлт, асуултуудыг сонсож, тодорхой хариултуудыг өглөө. Одоо хурлын дэгийн дагуу хэлэлцэж буй 3 асуудлаар санал хураалт явуулах ёстой байгаа. Тооллогын комиссын гишүүд та бүхэнд саналын хуудсыг тараан бөглүүлнэ. Тооллогын комиссын гишүүд хувьцаа эзэмшигч нарт саналын хуудсыг хэрхэн бөглөх талаар зааварчилгаа, чиглэл өгөөд явна уу.

За ингээд хэлэлцсэн асуудлууд дээр санал хураая. Санал хураалтын үйл явц 15-20 минут үргэлжилнэ. Энэ хугацаанд хувьцаа эзэмшигчид саналаа өгч дуусгах ёстой байгаа. Санал хураалтын үйл явцыг тооллогын комисс болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга тайлбарлаж өгнө үү.

Тооллогын комисс: Хувьцаа эзэмшигч нарт цаасаар саналын хуудас тарааж өгнө. Саналын хуудсыг буруу бөглөсөн болон засварласан тохиолдолд дахин 1 удаа саналын хуудас авч дахин бөглөх боломжтой. (гээд Тооллогын комиссын гишүүд саналын хуудсыг хэрхэн бөглөх болон кумулятив аргаар ТУЗ-ийн гишүүдийг сонгох зарчмыг тайлбарлан өгөв)

Хурлын дарга Я.Наваан: За хурлаар хэлэлцсэн асуудлууд дээр хувьцаа эзэмшигчид саналаа өгч дууссан байна. Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулна уу.

Тооллогын комиссын дарга Г.Өсөхбаяр: Санал хураалтын дүнг танилцуулъя. Энд хувь хүний нууцтай холбоотой асуудал яригддаг учраас хувьцаа эзэмшигчийн нэрийг дурдахгүйгээр санал хураалтын үр дүнг танилцуулах ёстой гэдгийг урьдчилж хэлье.

1-р асуудал буюу Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах асуудалд 19,583,015 ширхэг саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид буюу санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн 99.99% нь зөвшөөрсөн, 308 ширхэг саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид буюу санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн 0.0016% нь татгалзсан, 597 ширхэг саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид буюу санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн 0.0030% нь санал өгөхөөс түдгэлзсэн байна.

2-р асуудал буюу ТУЗ-ийн 2024 оны зардлын төсвийг батлах асуудалд 19,583,472 ширхэг саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид буюу санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн 99.99% нь зөвшөөрсөн, 299 ширхэг саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид буюу санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн 0.002% нь татгалзсан, 149 ширхэг саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид буюу санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн 0.001% нь санал өгөхөөс түдгэлзсэн байна.

3-р асуудал буюу ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудалд дараах байдлаар санал өгсөн байна.

ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдэд өгсөн саналын дүн:

1. Я.Наваанд нийт 19,581,783 ширхэг хувьцааны санал
2. И.Галбуянд нийт 19,580,081 ширхэг хувьцааны санал
3. А.Норсмаад нийт 19,580,149 ширхэг хувьцааны санал
4. Т.Сарантуяад нийт 19,580,064 ширхэг хувьцааны санал
5. Т.Амартерд нийт 19,580,036 ширхэг хувьцааны санал
6. Х.Эрдэнэбаатарт нийт 19,580,038 ширхэг хувьцааны санал

ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдэд өгсөн саналын дүн:

1. М.Дамирансүрэнд нийт 19,583,027 ширхэг хувьцааны санал
2. М.Ганцэцэгт нийт 19,582,495 ширхэг хувьцааны санал
3. Н.Энхчимэгт нийт 19,582,707 ширхэг хувьцааны санал
4. Б.Ганбаярт нийт 24,900 ширхэг хувьцааны санал

Хурлын дарга Я.Наваан: Санал хураалтын үр дүнтэй танилцлаа.

Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 99.99 хувийн саналаар зөвшөөрсөн тул уг асуудал батлагдлаа.

ТУЗ-ийн 2024 оны зардлын төсвийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 99.99 хувийн саналаар зөвшөөрсөн тул зардлын төсөв батлагдлаа.

ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудалд хувьцаа эзэмшигчдээс хамгийн олон санал авсан дараах 9 хүн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнээр сонгогдлоо.

ТУЗ-ийн ердийн гишүүд:

1. Я.Наваан
2. И.Галбуян
3. А.Норсмаа
4. Т.Сарантуяа
5. Т.Амартөр
6. Х.Эрдэнэбаатар

ТУЗ-ийн хараат бус гишүүд:

1. М.Дамирансүрэн
2. М.Ганцэцэг
3. Н.Энхчимэг

За санал хураалтын үр дүн тодорхой болсон учир та бүхэнд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолыг уншиж танилцуулъя.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 дүгээр
сарын 26-ны өдөр

Дугаар: 01

Улаанбаатар
хот

ТУЗ-ийн дүгнэлтийг
батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 04-р сарын 26-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

Я.НАВААН

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 дүгээр
сарын 26-ны өдөр

Дугаар: 02

Улаанбаатар
хот

ТУЗ-ийн зардлын төсвийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 04-р сарын 26-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны зардлын төсвийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд тогтоолын хавсралтаар батлагдсан цалин хөлсийг зохих журмын дагуу олгох, Төлөөлөн удирдах зөвлөлийн болон Хувьцаа эзэмшигчдийн хурлын зардлыг энэхүү тогтоолын хавсралтад заасан төсөвт багтаан гаргах, зардлын зарцуулалтыг компанийн санхүүгийн тайлан тэнцэлд зохих журмын дагуу бүртгэн тайлагнахыг Гүйцэтгэх захирал болон Ахлах нягтлан бодогч нарт даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Я.НАВААН

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 дүгээр
сарын 26-ны өдөр

Дугаар: 03

Улаанбаатар
хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь хэсэг, компанийн дүрмийн 7.3.4 дэх заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 04-р сарын 26-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр дор дурдсан нэр бүхий хүмүүсийг сонгосугай. Үүнд:
 - 1.1. Янсанжавын Наваан
 - 1.2. Идэштотгохын Галбуян
 - 1.3. Алтангэрэлийн Норсмаа
 - 1.4. Тэрбишийн Сарантуяа
 - 1.5. Төрөөгийн Амартөр
 - 1.6. Хүрэлхүүгийн Эрдэнэбаатар
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээр дор дурдсан нэр бүхий хүмүүсийг сонгосугай. Үүнд:
 - 2.1. Мөнхнасангийн Дамирансүрэн
 - 2.2. Нанзаддоржийн Энхчимэг
 - 2.3. Мэндсоогийн Ганцэцэг
3. Холбогдох хууль тогтоомж, компанийн дүрэм, дотоод үйл ажиллагааны дүрэм, журам зэрэг компанийн засаглалын тогтолцооны эрх зүйн баримт бичгийг мөрдөж ажиллахыг шинээр томилогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.
4. Шинээр томилогдсон ердийн болон хараат бус гишүүдийн талаарх мэдээллийг холбогдох эрх зүйн актад тусгасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн биржид тус тус мэдэгдэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /М.Өлзийбат/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Я.НАВААН

Ингээд хурлын үйл ажиллагааг дуусгая. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нартаа баярлалаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 12:15 цагт дуусав.

ТЭМДЭГЛЭЛИЙГ ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:

ХУРЛЫН ДАРГА



Я.НАВААН

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



М.ӨЛЗИЙБАТ